

МЭДЭЭЛЭЛ

Доктор У.Лигаагийн мэндэлсний
90 жилийн ойд

Эмийн ургамал судлаач, биологийн ухааны доктор (Ph.d) Уртнасангийн Лигаагийн ботаникийн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр



Доктор У. Лигаа 1932 онд Хөвсгөл аймгийн Галт сумын/ нутаг Бургастад төрсөн. 1941-1945 онд Галт сумын бага сургууль, 1945-1951 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотын 10 жилийн дунд сургууль, 1951-1956 онд Монгол Улсын Их Сургуулийн Мал эмнэлгийн ангид тус, тус суралцан төгсөж малын их эмчийн мэргэжил эзэмшжээ. 1956-1963 онд Дорнод аймгийн Эрэнцавын сангийн аж ахуйд малын их эмч, 1964-1969 онд Шинжлэх ухааны Академийн харьяа Ж.Самбуугийн нэрэмжит Мал аж ахуйн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1969-1972 онд ОХУ-ын Санкт-Петербург хотод аспирантурт суралцан “Монгол орны тарваган шийр төрлийн зүйлүүдийн ангилал зүй, биологи-экологи, тархац, нөөц, улс ардын аж ахуйн ач холбогдол” сэдвээр дэд



эрдэмтний зэрэг хамгаалан, ургамлын ресурс, эдийн засгийн ургамал судлагчийн нарийн мэргэжлийн диплом авсан ба 2006.05 сард АНУ-ын Намтар Судлалын Хүрээлэнгээс Эмийн ургамлын баталгаажсан мэргэжилтэн. Тусгай мэргэжлийн үнэмлэх гардан авсан.

Түүнчлэн Доктор У. Лигаа нь Чингис хааны дэлхийн Академийн жинхэнэ гишүүн, Монголын Хөдөө Аж Ахуйн шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, Дэлхийн ба Монголын шингэн кристаллын холбооны гишүүн, АНУ-ын Намтар судлалын хүрээлэнгийн зөвлөхүүдийн эрдэм шинжилгээний зөвлөлийн гишүүн хүн юм.

Доктор У. Лигаа 1973 оноос ШУА-ийн харьяа Биологийн хүрээлэнд, 1974-1985 онд ШУА-ийн Ботаникийн








хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, ахлах ажилтан, тэргүүлэх ажилтан, секторын эрхлэгч, монгол-зөвлөлтийн /хуучин нэрээр/ биологийн хамтарсан иж бүрэн экспедицийн ашигт ургамлын баялаг судлалын отрядын монгол талын дарга, 1986-1992 онд “Хүнс, эмийн ургамлын зарим төлөөлөгчдийн цэцэглэх, үр боловсруулах биологийн онцлогийг судалж бүтээгдэхүүний гарцыг тогтоох, прогнолох арга боловсруулах” сэдэвт хамаарах “Хүнс, эм, тэжээлийн зонхилох төлөөлөгчдийг популяцийн түвшинд судлах” дэд сэдэвт ажил хариуцахын хамт Говийн ашигт ургамал тарималжуулах станцын эрдэм шинжилгээний удирдагчаар ажилласан. Эрдэмтэн багш маань эмийн ургамал судлал, ашигт ургамлын тархац, нөөц судлал, ашигт ургамал тарималжуулах, нутагшуулах, угсаатны ургамал судлал зэрэг чиглэлээр эрдэм шинжилгээ, судлагааны ажил гүйцэтгэн эдийн засгийн ургамал судлаач, эрдэмтэдтэй хамтран монгол орны ашигт ургамлын бүртгэлийг хэрэглээний салбаруудаар зэрэглэн ашиглах чиглэлийг анх удаа тодорхойлон бэлчээр болон эмийн 1000 гаруй, балт тоост 593 зүйл, гоёл чимэглэлийн 480 гаруй, хүнс, техникийн, будагт тус бүр 200 орчим, эфирийн тост 170 гаруй зүйл ургамал байгааг ангилан тодорхойлсон ба эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээс “БНМАУ-ын ашигт ургамлын тархац, нөөцийн атлас” хэмээх хамтын бүтээлд 40 гаруй ургамлын тархац, 10 гаруй ургамлын нөөцийг харуулсан зураглал үйлдэх болон 100 гаруй ургамлын холбогдох өгүүлэл зохиоход бие даан болон бусадтай хамтран оролцож уул бүтээлийн редакцийн зөвлөл хийгээд коллегийн нарийн бичгийн даргаар ажилласны зэрэгцээ мөн тус секторын эрдэм шинжилгээний ажилтан нартай хамтран туурвисан “БНМАУ-ын жимс, жимсгэнэ, самар, хүнсний мөөгийн тархац, нөөцийн альбом”, “Монгол орны ашигт ургамлын тархац-нөөцийн атлас”, “Монгол орны зэрлэг ашигт ургамал” бүтээлүүдийг зохиоход оролцсон байна.







У. Лигаа Монгол улсын их сургууль төгсмөгцөө эмийн ургамлыг мал эмнэлгийн практикт ашиглах ажлыг гардан зохион байгуулж шаргал лидэр, урал чихэр өвс, сөд, яргуй, тарваган шийр, нарс /шилмүүс/ зэрэг 10 шахам зүйл ургамлыг мал, төлийн өвчин анагаах, сэргийлэхэд хэрэглэсэн туршилтын ажлын

дүнгээр “Орон нутгийн эмийн ургамлыг мал эмнэлгийн практикт ашиглая” (1964) “Төлийг витамингүйдэх өвчнөөс сэргийлэх” (1966), “Төлийг хордлогоос урьдчилан сэргийлэх” (1967), “Монгол орны алкалоид агуулдаг ургамлын нэрсийн жагсаалт” (1971), “Лидрийг мал эмнэлэгт хэрэглэх нь” (1969) зэрэг товхимлыг бичсэн.



У. Лигаа нь эрдэм шинжилгээний ном, товхимол, хамтын бүтээл 35-ыг бие даан болон бусадтай хамтран туурвисны дотор бие даан бичсэн 7 номд монгол улсын зохиогчийн эрхийн гэрчилгээ авч, эрдэм шинжилгээний болон хялбаршуулсан өгүүлэл 135, хүнс, эмийн ургамлыг түүж бэлтгэх, ашиглах, стандарт 14, заавар 6, зөвлөмж болон техник, эдийн засгийн үндэслэл тус бүр 1, патент 12-ийг бусадтай хамтран боловсруулж үйлдвэрлэл, практикт нэвтрүүлж оновчтой саналын гэрчилгээ 3-ыг авчээ. Мөн фитонцидот ургамлыг ашиглан эмчилгээний цэцэрлэг байгуулах ажлыг санаачлан Сөгнөгөр, Хужирт, Оргил болон Хөвсгөл аймгийн Галт сумын нутаг дахь Халуун рашаан усны амралт сувилалын газар “Эмчилгээний цэцэрлэг” байгуулсан нь ард иргэдийн өвчнийг эмчлэх, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд чухал ач холбогдлоо өгсөөр байна.

Доктор У. Лигаа нь “Монголын улаан ном (1987, 1997, 2013) түүнчлэн хүнс, эм, тэжээлийн онцгой ач холбогдолтой болон ховор, нэн ховор 50 гаруй зүйл ургамлын 1000 гаруй бодгаль, эгэл годил, кузнецовын хорс, бавгар үрт агчаахай, шаргал лидэр, дагуур цооргоно, марцны цахирам, монгол хундгана, сибирь хундгана, алтан гагнуур зэрэг 20 гаруй зүйл ховор, нэн ховор ургамлын генийн санг хамгаалан устах аюулаас сэргийлэх, байгаль хамгаалах үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулсан байна.



Эрдэмтэн У. Лигаа Ашигт ургамал судлал, Эмийн ургамал судлалын хичээлийн дагуу МУИС, АУИС, ХААИС-д 20 шахам жил хичээл зааж, “БНМАУ-ын байгалийн ашигт ургамал” (1985); 530 зүйл ургамал, 255 нэрийн жор бүхий “Монгол уламжлалт эмнэлэгт эмийн ургамлыг хэрэглэх арга ба жор” (1996; 1997) 2 боть, 740 гаруй зүйл ургамлыг Ази, Европ тивийн олон оронд хэрэглэдэг туршлага, ололт, амжилтыг дурдсан 500 гаруй зүйлийн төвд нэрийн гарлыг тогтоож “Монгол орны эмийн ургамлыг өрнө, дорнын анагаах ухаанд

хэрэглэхүй” (2006), “Хэрлэнгийн хөдөө аралд тарьсан нэн ховор, ховор ашигт ургамал” (2011) зэрэг бүтээлийг нийтийн хүртээл болгосон нь монгол уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололт, амжилтаар баяжуулан нэгтгэн дүгнэсэн томоохон ач холбогдолтой төдийгүй их, дээд сургууль болон холбогдох мэргэжилтэн судлаачдын гарын авлага, ширээний ном болжээ.

Доктор Лигаа нь эрдмийн бүтээлээ орос англи хэлээр бие даан туурвидгийн дээр түүний бүтээлийг онол, аргагүйн өндөр түвшинд бичигддэг гэж уншигчид үнэлдгийн нэгэн жишээ нь У.Лигаагийн “Монгол уламжлалт эмнэлэгт эмийн ургамлыг хэрэглэх арга ба жор ” ном нь 1997 оны шилдэг бүтээлээр шалгарч гэрчилгээ авч байсны дээр түүний хэд хэдэн бүтээлийг Америк, Энэтхэгийн конгрессийн номын санд тавьжээ.

Түүнчлэн хэд хэдэн эрдэм шинжилгээний бүтээл нь ОХУ, Солонгос, Герман, Америк, Англи, Канад улсад хэвлэгдсэн байна. “Монгол орны эмийн ургамал монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэгдэх” нь хэмээх 25 орчим хэвлэлийн хуудас номоо англи хэлээр бие даан бичсэнийг нь солонгос хэлнээ орчуулж англи, солонгос хэлээр Сөүл хотноо КСА хэвлэлийн газар 1996 онд хэвлэн гаргажээ. Орос – Монголын биологийн хамтарсан иж бүрэн экспедицийн нөөц судлалын отрядын 10 гаруй жил цуглуулсан материал дээр үндэслэн бичсэн “БНМАУ-ын байгалийн ашигт ургамал” хэмээх бүтээл Ленинград хотноо 1985 онд орос хэлээр хэвлэгдэн гарсан.

Монголын байгалийн шинжлэх ухааны салбарын тэргүүлэх эрдэмтдийн англи хэлээр туурвисан өнөөдрийн монгол /хөгжил, шинжлэх ухаан, соёл, боловсрол/ хамтын бүтээлд У. Лигаа зохиогчоор оролцсон бөгөөд энэ ном англи, АНУ, Канадад 2003 онд хэвлэгджээ.

Түүнчлэн Эрдэмтэн Лигаагийн эрдэм шинжилгээний ажил бүтээлийн тухай Монголын шилдэг тэргүүний хүмүүсийн намтар, ном бүтээлийг олон түмэнд толилуулдаг “Монголын алтан ном”-ын II боть; Монгол улсын шинжлэх ухаан, Монголын уламжлалт анагаах ухааны түүх зэрэг бүтээлүүдэд хэвлэн нийтэлсэн байдгаас гадна Английн намтар судлалын төвийн “Dictionary of international Biography. 2007. Thirty third Edition” номын 639-640-р талд; АНУ-ын намтар судлалын хүрээлэнгийн “Great Minds of 21st Century. 2005. Second Edition. Номын 178-р талд; мөн хүрээлэнгийн “International Dictionary of Experts and Expertise. 2008. Premier Edition номын 172-173-р талд тус тус хэвлэн нийтэлжээ.”

У.Лигаагийн хөдөлмөр бүтээлийг монголын төр засгаас өндрөөр үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон /2018/, Төрийн соёмбо хүндэт тэмдэг, тэргүүн зэргийн өргөмжлөл /2013/, Монголын Залуучуудын Холбоо. Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч /2012/, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан /2008/, ШУАкадемийн хүндэт жуух /2007/, Баянгол дүүргийн хүндэт тэмдэг /2007/, Байгаль орчны тэргүүний ажилтан /2006/, Алтан гадас одон /2002/, Хөдөлмөрийн хүндэт медаль /1982/, Ардын Хувьсгалын 60, 70, 80, 90 жилийн ойн медалиуд /1971, 1981, 1991, 2011/, Засгийн газрын хүндэт жуух бичиг /1963/, Сангийн аж ахуйн тэргүүний ажилтан /1961/, Монголын ахмадын холбооны хүндэт тэмдэг /2002/, Хөдөө аж ахуйн тэргүүний залуу /1957/ зэрэг цол, шагнал хүртээжээ.



Түүнчлэн эмийн ургамал судлаач эрдэмтэн Лигаагийн эрдэм шинжилгээний бүтээлийг гадаадын эрдэм шинжилгээний байгууллагууд өндрөөр үнэлж Английн Кембриджийн намтар судлалын төв 21-р зууны гавьяатнаар тодруулж гэрэлт диплом, медаль /2003/, Дэлхийн тэргүүлэх эрдэмтний диплом /2006/, Америкийн нэгдсэн улсын намтар судлалын хүрээлэн 21-р зууны суут ухаантаар тодруулж өргөмжлөл /2004/, эмийн ургамлын баталгаажсан мэргэжилтний диплом /2006/, Америкийн нэгдсэн улсад 2006 онд чуулсан соёлын нэгдсэн их хурлаас “Олон улсын энх тайвны шагнал”, Шинжлэх Ухаан Техникийн олон улсын гавьяатын одон /2008/, Анагаах ухааны олон улсын гавьяатын одон (2008) тус тус олгожээ.

Монгол орны ашигт ургамал судлал болон эмийн ургамал судлалд өөрийн бүхий л амьдрал, авьяас чадвараа зориулан уйгагүй хөдөлмөрлөж, эрдэм шинжилгээний бүтээл, туурвилаараа Монгол болоод дэлхийн улс орнуудад танигдан алдаршиж, өргөн мэдлэг, арвин туршлагаа үе үеийн шавь нартаа түгээн дэлгэрүүлж яваа, эрхэм баян эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгч эгэл даруухан, эрдэм төгс доктор У.Лигаа багшдаа 90 насны ойн баярын мэндийг хүргэж эрүүл энх, сайн сайхныг бүхнийг хүсэхийн зэрэгцээ эрдэм номын цагаан буян ашид дэлгэрч, бүтээл туурвил арвин байхын өлзийтэй ерөөлийг үе үеийн хамт олон, шавь нарынх нь хамт өргөн баръя.

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн
Ургамалжлын экологи, ургамлын эдийн засгийн лабораторийн
эрдэм шинжилгээний дэд ажилтан, доктор (Ph.D) Ц.Батцэрэн
Ахмад эрдэмтэн Доктор (Sc.D.), Г.Очирбат, Магистр Б. Мөнхжаргал